



МОНГОЛ УЛС
ТОВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 17 өдөр

Дугаар A/367

Зуунмод

Газар эзэмших эрх шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Дэнзэндорж овогтой Ширбазар /НЭ66082572/-ын нэгж талбарын 4110062226 дугаартай Номт 1-р баг, Соёл хотхон, Тээвэрчдийн гудамж 104 тоотод амины орон сууц /Таун хаус/-ны зориулалттай 200m² газрын эзэмших эрхийг Төмөрбаатар овогтой Батнасан /НФ85111419/-д амины орон сууцны зориулалтаар 13 жилийн хугацаагаар эрх шилжүүлэн эзэмшигжүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Т.Батнасанд дараах үүргийг хариуцуулсугай.

2.1 Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2 Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3 Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4 Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, архитектур төлөвлөлтийн дагуу барилга байгууламж барих,

3. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Огтонбат/, Зуунмод сумын Засаг дарга/Г.Мөнхбадрал/ нарт дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1 Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.


3.2 Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.3 Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/469 дүгээр захирамж болон газар эзэмших эрхийн 000688566 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ



010 01147